



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/93

Хажуу шинэ-Ус

Шүлхий өвчнөөс урьдчилан  
сэргийлэх дархлаажуулалтын  
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-9.8 дахь заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын А/251 дугаар тушаал, Аймгийн засаг даргын А/588 тоот захирамжыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг 2023 оны 10 дугаар сарын 09-ны өдрөөс эхлэн шуурхай зохион байгуулж ажиллахыг Угтаал чандмань хоршоо мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч (Д.Амгалан)-д үүрэг болгосугай.

2.Малчин мал бүхий өрхөд зарлан мэдээлэл хүргэж малыг бэлэн байлгаж бүрэн хамруулж ажиллахыг 1 дүгээр багийн Засаг дарга (Б.Гүнсэнтүг), 2 дугаар багийн Засаг дарга (Амарзаяа), 3 дугаар багийн Засаг дарга (Б. Даваасүрэн) нарт даалгасугай.

3.Дархлаажуулалтын ажилд хяналт тавин мэргэжлийн арга зүйгээр хангаж үр дүнг тайлагнаж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (А.Бямбадорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Т.АРИУНАА

482301093